# БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

БАЙГУУЛЛАГЫН НЭР: ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

БАТАЛГААЖУУЛСАН:
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ,
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

.............................. Б.ЗОРИГТБАЯР

Тамга .............................. *(огноо)*

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА

.............................. Ж.БААСАНСҮРЭН

Тэмдэг .............................. *(огноо)*

НЭГТГЭЖ ТАЙЛАГНАСАН:
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА

.............................. Ц.ЭРДЭНЭЧИМЭГ

Тамга 2025.12.04. *(огноо)*

## ОРХОН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

### НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго-1: ӨМЧИЙН УДИРДЛАГА, ХЯНАЛТ ШАЛГАЛТ<br>Орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн удирдлагад хяналт тавьж, бүрэн бүтэн байдлыг хангуулах зарчимд тулгуурласан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах** | | | | | | | |
| 1.1 | ЗОРИЛТ-1: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад баримтын иж бүрэн болон системийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээнд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх /ЗГХЭГ-ын сайд-2.3.6/ | | | | | | |
| 1.1.1 | Арга хэмжээ-1: Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд баримтын хяналт шалгалт хийх | Байгууллагын төсвөөр | Баримтын шалгалтад хамрагдах хуулийн этгээдийн тоо | - | Төлөвлөгөөний биелэлт, танилцуулга, цаашид авах арга хэмжээ, арга хэмжээний үр дүнг гаргасан байна. | Орон нутгийн өмчит Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ, Эрдэнэт ус ДТС ОНӨХК, Хот тохижуулах газар УТҮГ-т санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа болон эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад хийх хяналт шалгалтын удирдамж, төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр 3 бүлэг, 38 заалттайгаар батлуулсан.<br>Батлагдсан удирдамжийн дагуу "Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ-т 2025 оны 05 дугаар сарын 01-нээс ажлын 30 өдөр, "Эрдэнэт ус ДТС" ОНӨХК-д 2025 оны 06 дугаар сарын 16-наас ажлын 45 өдөр, "Хот тохижуулах газар" УТҮГ-д 2025 оны 10 дугаар сарын 29-нөөс ажлын 15 өдөрт хяналт, шалгалтыг хийж, үр дүнг танилцуулж ажилласан. Мөн аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 08/2480 дугаар албан бичгийн дагуу "Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк" ОНӨААТҮГ-ийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтаар олж авсан тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалтад төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг 2025 оны 11 дүгээр сарын 13-наас ажлын 12 өдөрт хийж гүйцэтгэсэн. | 100 хувь<br>100% |
| 1.1.2 | Арга хэмжээ-2: Орон нутгийн өмчит төсөвт байгууллагуудын өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтад | Байгууллагын төсвөөр | Шалгалтад хамрагдах хуулийн этгээдийн тоо | Орон нутгийн өмчит 97 байгууллагад системийн хяналтыг хийж, 1248 нэр төрлийн 2.5 тэрбум | Төлөвлөгөөний биелэлт, танилцуулга, цаашид авах арга хэмжээ, арга хэмжээний үр дүнг гаргасан байна. | Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын системийн шинэчлэлттэй холбоотойгоор орон нутгийн өмчит 100 хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн бүртгэлийн үнэн зөв байдалд системийн хяналт тавьж ажилласан. Үүнд:<br>Урсгал засварын шинжтэй зардлыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн, их засварын шинжтэй капиталжуулах зардлыг биет хөрөнгөд бүртгэсэн тохиолдол бүрийг илрүүлж 63 | 100 хувь<br>100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | системийн хяналт шалгалт хийх | | | төгрөгийн хөрөнгийн бүртгэл залруулсан. | | байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт зөвлөмж хүргүүлсэн.<br>Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/260 дугаар захирамжийн дагуу 59 байгууллагын 8,029,246,199.00 төгрөгийн 615 нэгж хөрөнгийн ангилал залруулах, 11,984,078,186.00 төгрөгийн 204 нэгж хөрөнгийг барилга, байгууламж дансанд капиталжуулан бүртгэх ажлын хөдлөл өөрчлөлтийг системд хийсэн.<br>63 хуулийн этгээдийн нэрийг улсын бүртгэлийн гэрчилгээтэй тулган системд засварлан бүртгэсэн. Мөн газар эзэмшилт, ашиглалттай холбоотойгоор 78 байгууллагыг 391 газрыг www.egazar.gov.mn, 40 байгууллагын 401 тээврийн хэрэгслийн бүртгэлийг www.transdep.mn цахим бүртгэлтэй тус тус тулган баталгаажуулсан.<br>Мөн 2022 онд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээнд хамрагдаж, одоо ашиглалтын шаардлага хангахгүй болсны улмаас ашиглах боломжгүй байгаа хөрөнгийг актлах хүсэлтэй 16 байгууллагын хүсэлтийн дагуу хөрөнгөд хяналт тавьж, 56,225,137.81 төгрөгийн балансын үнийн дүнтэй, 33,492,142.20 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 22,732,995.61 төгрөгийн үлдэх өртөгтэй 160 нэгж хөрөнгийг актлуулах захирамжийн төсөл боловсруулж, аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/1003 тоот Хөрөнгө актлах тухай захирамжийг гаргуулсан. | |
| 1.1.3 | Арга хэмжээ-3: Хяналт шалгалтын бүртгэлийн нэгдсэн сан бий болгох, бүртгэл мэдээллийн баяжилт хийх | Байгууллагын төсвөөр | Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн иж бүрдлийн хувь | - | Төлөвлөгөөний биелэлт, танилцуулга, цаашид авах арга хэмжээ, арга хэмжээний үр дүнг гаргасан байна. | Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, бүртгэл, зохицуулалтын шинэ системд "хяналт шалгалтын модуль" шинээр нэмэгдэж байгаатай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн "Цахим систем нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээний тухай" А/07 дугаар тушаал гарсан. Үүний дагуу аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/94 дүгээр захирамжаар Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системийг нэвтрүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, төлөвлөгөөг батласан. Захирамжийн дагуу төлөвлөгөөт ажлуудыг хийж гүйцэтгэн шилжилтийн системд орон нутгийн өмчит 100 хуулийн этгээдийн санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг хүлээн авч нэгтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр хүргүүлсэн.<br>Мөн батлагдсан төлөвлөгөөний дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн системийг Орхон | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймгийн Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад урьдчилан нэвтрүүлэх ажлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөс 07 дугаар сарын 04-ний өдрийн хооронд хийсэн. Шинэ системийн туршилтыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, ЭБЦТС ТӨХК, Эрдэнэтийн ДЦС ТӨХК, "АЗЗА нэгтгэл" ТӨХК-ийн Орхон аймаг дахь салбар, Орхон аймгийн Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Орхон аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс, Онцгой байдлын газар, Гаалийн газар зэрэг төрийн өмчит 8 байгууллага, Орхон аймгийн ЗДТГ, Орон нутгийн өмчийн газар, Жаргалант сумын ЗДТГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Эрдэнэт ус ДТС ОНӨХК, 3 дугаар сургууль, Хот тохижуулах УТҮГ, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, 17 дугаар цэцэрлэг, Цагдаагийн газар зэрэг орон нутгийн өмчит 10 байгууллагад хийж, заавар, зөвлөгөө өгсөн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн А-1/1538 тоот албан бичгийн дагуу "Төрийн болон орон нутгийн өмчийн цахим систем"-ийн үйл ажиллагааг нэвтрүүлэх, улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын нэгдсэн цахим системтэй холбох ажлын хүрээнд сургагч багш бэлтгэх сургалтад 4 албан хаагч 2025 оны 08 дугаар сарын 25-аас 28-ны өдрүүдэд хамрагдсан. 2025 оны 10 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн Б.Мөнхбаяр, Аствишн ХХК-ийн систем шинжилгээ, загварчлалын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Долгоржав, Орон нутгийн өмчийн газрын сургагч багш нар хамтран шинэ цахим системийн талаарх сургалтыг Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Төрийн болон орон нутгийн өмчит 126 байгууллагын 135 албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго-1.2: ӨМЧИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨӨЛӨЛ**<br>**Орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн удирдлагыг оновчтой, үр ашигтай, бүтээмжтэй байх зарчимд тулгуурласан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах** | | | | | | | |
| 2.1 | ЗОРИЛТ-2: Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлэх / ЗГҮАХ-3.1.2.4, ЗГХЭГ-ын сайд-2.3.1, 2.3.2, 2.3.3, 2.3.4, 2.3.5/ | | | | | | |
| 2.1.1 | Арга хэмжээ-1: Орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Байгууллагын төсвөөр | Тайлан, биелэлтийн тоо | Орхон аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/90 дугаар захирамжаар томилогдсон Орон нутгийн | Орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлсэн ажлын тайлан, удирдамжийн биелэлтийг гаргасан байна. | Орон нутгийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай" А/25 дугаар захирамжаар байгуулсан. Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 02/17 дугаар тогтоолоор "Орон нутгийн өмчит компаниудын хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл"-ийг томилсон. | 100 хувь<br>50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх, шалган зааварчлах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг 2024 оны 4 дүгээр сарын 5, 7, 9, 10-ны өдрүүдэд ажилласан. | | Аймгийн Засаг даргын А/25 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийн материалыг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсан.<br>"Эрдэнэт ус ДТС" ОНӨХК, "Жаргалант ус ДТС" ОНӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг тус бүр 9 гишүүнтэйгээр байгуулж, ТУЗ-ийн гишүүдийн хувийн ашиг, сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулж "Эрдэнэт ус ДТС" ОНӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01/01 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр Хотын захирагчийн албаны дарга Б.Одгэрэл, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга С.Даваадорж, аймгийн ИТХ-ын Бодлого, төлөвлөлт, хууль, эрх зүйн хэлтсийн дарга Б.Тунгалаг, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баттүвшин, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч С.Энхтүвшин, Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Эрдэнэчимэг, EBS телевиз, TV-9 инфо сүлжээ, Монголын радиогийн Орхон аймаг дахь сурвалжлагч Ж.Баяртогтох, Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэн, Татварын мэргэшсэн нягтлан бодогч В.Хандмаа нарыг, "Жаргалант ус ДТС" ОНӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01/01 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр аймгийн ЗДТГ-ын дарга Б.Ганзориг, аймгийн ИТХ-ын Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтсийн дарга Б.Золоо, аймгийн СТСХ-ийн дарга Л.Ганлсансайнхувьт, Жаргалант сумын ИТХ-ын Нарийн бичгийн дарга Ц.Ганбаяр, Орон нутгийн өмчийн газрын Өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Баттөр, Хотын захирагчийн албаны Барилгын инженер, ахлах мэргэжилтэн Г.Тулгабаатар, "Эрдэнэт ус ДТС" ОНӨХК-ийн Дулааны инженер Ц.Одбаяр, Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэн Ё.Пэрэнлиймаа, "Холл" ХХК-ийн Санхүүгийн зөвлөх Д.Наранмандах нарыг томилсон. | |
| 2.1.2 | Арга хэмжээ-2: Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах, тайлагнах | Байгууллагын төсвөөр | Арга хэмжээний тоо | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх | Төлөвлөгөөний биелэлт, танилцуулга, цаашид авах арга хэмжээ, арга хэмжээний үр дүнг гаргасан байна. | Аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/144 дүгээр захирамжаар аймгийн Засаг даргатай "Хөдөлмөрийн онцгой нөхцөл бүхий гэрээ" байгуулдаг орон нутгийн өмчит 4 аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит 2 хувьцаат компани, 4 улсын төсөвт үйлдвэрийн газрын 2024 оны ажлын тайлан, 2025 оны бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны | ~~100 хувь~~ 70% |

0 [illegible]

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | удирдлагуудад зориулсан | | төлөвлөгөөг хянаж үнэлэлт дүгнэлт өгч тайлагнах ажлын хэсэг байгуулагдсан. | |
| | | | | "Компанийн засаглал"-ын сургалтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зохион байгуулсан.<br>Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит компанийн статусыг өөрчлөх, санхүүгийн үзүүлэлтийн харьцуулалт судалгаа хийж, жишиг дүрмийг шинэчлэн боловсруулсан. | | Орон нутгийн өмчийн хувьцаат компани, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын 2024 оны ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж, дүгнэхдээ 10 шалгуур үзүүлэлтийн дагуу, улсын төсөвт үйлдвэрийн газруудын 2024 оны ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж, дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө", 7 дугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн тайлан"-ийн маягтын дагуу төлөвлөж, тайлагнасан байдал, ажлын үр дүн зэрэгт үнэлгээ өгч аймгийн Засаг даргад танилцуулан ажилласан.<br>"Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ 93,87%, "Хот тохижуулах газар" УТҮГ 92,4%, "Эрдэнэт-Ус ДТС" ОНӨХК 91%, "Нийтлэг үйлчилгээний алба" УТҮГ 86,5, "Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж" УТҮГ 81,2%, "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн" АӨЗ 80,4%, "Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ 75%-аар "ХАНГАЛТТАЙ" үнэлгээ авсан.<br>"Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ 17,7%, "Жаргалант-Ус ДТС" ОНӨХК 29,6%, Эрдэнэт ШУТП 0%-аар ХАНГАЛТГҮЙ үнэлгээ авсан байна.<br>Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт:<br>1. Хугацаатай албан бичгийг хяналтдаа авч хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж байх;<br>2. Ажил сайжруулах дүгнэлт, зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангах, тайлагнах;<br>3. Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4, 7 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу төлөвлөж, тайлагнах;<br>4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа зорилтыг хэрэгжүүлэх эрх зүйн актын уялдаа, шалгуур үзүүлэлт, суурь түвшинг зөв тодорхойлох;<br>5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хананган ажиллах;<br>6. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын ажлын төлөвлөгөө, тайлан хариуцсан албан хаагчдыг | [illegible] |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чадавхижуулах сургалтад хамрагдуулж, ажлын чанарыг сайжруулах;<br>7. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, хэрэгжилтийг тухай бүр Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж байх гэсэн зөвлөмжийг хүргүүлсэн.<br>Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, ажлын чанар, үр дүнд анхааран ажлаа сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг байгууллагын дарга, захирал нарт мэдэгдсэн.<br>Компанийн засаглалын сургалтыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын алба, "Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ" ОНӨХК-тай хамтран 2025 он 12 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөн "Жаргалт хаан хайрхан консалтинг" ХХК-тай гэрээ байгуулсан байна. | |
| 2.1.3 | Арга хэмжээ-3: Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулах, үйлдвэрлэл, технологи, техник санхүү эдийн засаг, хүний нөөцийн төлөв байдалд судалгаа, шинжилгээ хийх, санал, дүгнэлт гаргах, алдагдалыг бууруулах ажлыг зохион байгуулах | Байгууллагын төсвөөр | Төлөвлөгөө боловсруулсан байх | Орон нутгийн өмчит байгууллагуудын захирал, дарга нар аймгийн Засаг даргатай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулахад Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг | Төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнасан байна. | Орон нутгийн өмчит 4 үйлдвэрийн газар, 2 компани, 4 улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга, захирал, удирдлагуудын аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны Хөдөлмөрийн онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хавсралтаар оруулж батлуулсан бөгөөд Төлөвлөгөөний хэрэгжилтийг дараах 7 байгууллагаас авч, зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.<br>**Үүнд:**<br>• "Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ - **64.44 хувь**,<br>• "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн" АӨЗ - **83.75 хувь**,<br>• "Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ - **52.05 хувь**,<br>• "Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн газар" УТҮГ - **53.04 хувь**,<br>• "Хот тохижуулах газар" УТҮГ - **71.93 хувь**,<br>• "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" УТҮГ - **64.03 хувь**тай тус тус үнэлэгдсэн бөгөөд<br>**Эрдэнэ шинжлэх ухаан, технологийн парк** нь ажлын тайлан ирүүлсэн боловч 2025 оны төлөвлөгөөг батлуулаагүй тул үнэлэх боломжгүй байна. | ~~90~~ хувь 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тусгаж ажилласан. | | | |
| 2.1.4 | Арга хэмжээ-4: Орон нутгийн өмчөөс худалдах эд хөрөнгийн жагсаалтыг гаргах, зохион байгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах, орон сууц хувьчлах товчооны үйл ажиллагаанд оролцох | Байгууллагын төсвөөр | Төслийн тоо | Орон нутгийн өмчийн орон сууц хувьчлах ажлыг Орон сууц хувьчлах хуулийн дагуу удирдлага, зохицуулалтаар хангаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | Хувьчлах хөрөнгийн танилцуулга, мэдээллийн төслийг бэлтгэж ажилласан байна. Ажлын тайланг гарган танилцуулсан байна. | Орон нутгийн өмчит 41 байгууллагад олон жил ашиглагдан ашиглалтын хугацаа дууссан, техникийн хяналтын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүйг тодорхойлж, цаашид ашиглах боломжгүй болсон 822,254,014 төгрөгийн балансын үнийн дүнтэй, 813,404,014 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 8,850,000 төгрөгийн үлдэх өртөгтэй 19 нэгж хөрөнгийг акталж, шаардлагатай хэсгийг сэлбэг хэрэгслээр ашиглаж, үлдсэн хэсгийг төмрийн хаягдалд тушаасан. 169,100,000 төгрөгийн балансын үнийн дүнтэй, 152,751,040.93 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 16,348,959.07 төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 7 нэгж хөрөнгийг үнэ тогтоон худалдсан.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолоор батлагдсан журмын дагуу төрийн өмчит байгууллагуудаас худалдах тээврийн хэрэгслийн дуудлагын худалдааг зохион байгуулан ажилласан. Үүнд: Орхон аймаг дахь Шүүх шинжилгээний хэлтэст ашиглагдаж байгаа 00-94 ОРО улсын дугаартай Хьюндай старекс маркийн тээврийн хэрэгслийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 10 цагт мэргэжилтэн Б.Төгөлдөржаргал, А.Сарангэрэл, Б.Дашмаа нар зохион байгуулж уг тээврийн хэрэгслийг 4,000,000 төгрөгөөр, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-аас "Дуудлагын худалдаа зохион байгуулах тухай" 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 01/192 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 10 цагт мэргэжилтэн Б.Төгөлдөржаргал, А.Сарангэрэл нар дотоод үйлчилгээнд ашиглагдаж байсан 6510 краз самосвал өөрөө буулгагч, 10 тн-ын даацтай 22-18 ОРА улсын дугаартай тээврийн хэрэгслийг дуудлагын худалдаагаар 2,000,000 төгрөгөөр, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-аас "Дуудлагын худалдаа зохион байгуулах тухай" 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 01/948 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 10 цагт мэргэжилтэн Б.Дашмаа, А.Сарангэрэл нар нүүрс түрэлтэд ашиглагдаж байсан Д3-110 маркын 16.5 тн-ын даацтай Бульдозер маркын тээврийн хэрэгслийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг зохион байгуулж 850,000 | ~~100 хувь~~ 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгөөр тус тус худалдсан. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго-1.3: ӨМЧИЙН АШИГЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ, БҮРТГЭЛ МЭДЭЭЛЭЛ** <br> **Орон нутгийн өмчийг үр ашигтай, үр дүнтэй, бүтээмжтэй байх зарчимд тулгуурласан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах** | | | | | | | |
| 3.1 | ЗОРИЛТ-3: Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх, төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, үр өгөөж, хяналтыг сайжруулах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэх / ЗГҮАХ-4.1.4.2, ЗГХЭГ-ын сайд-2.3.7/ | | | | | | |
| 3.1.1 | Арга хэмжээ-1: Төрийн өмчөөс орон нутгийн өмчид, орон нутгийн өмчөөс эд хөрөнгийг төрийн өмчид, орон нутгийн өмчит байгууллагын эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх асуудлыг тухай бүр судлан шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангах, тайлагнах | Байгууллагын төсвөөр | Шийдвэр гарч, хэрэгжсэн байна. | Хөрөнгө шилжүүлэх тухай аймгийн Засаг даргын 8 удаагийн шийдвэрийг гаргуулж хэрэгжилтийг хангаж ажилласан. | Эд хөрөнгө шилжүүлэх асуудлыг тухай бүр судлан шийдвэрлүүлсэн байна. | Орон нутгийн өмчийн байгууллага хооронд балансаас балансt хөрөнгө шилжүүлэх 19 байгууллагын хүсэлтийг хүлээн авч тухай бүр шийдвэрлэн ажиллаж байсан. Үүнд: Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/44 дугаар захирамжаар Орон нутгийн өмчийн газрын санхүүгийн тайланд бүртгэлтэй 183,100,933.84 төгрөгийн балансын өртөгтэй 26,795,258.64 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 156,305,675.20 төгрөгийн үлдэх өртөгтэй Эрдэнэт үйлдвэрлэл технологийн паркын барилгыг Сум дундын ойн ангид, 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/224 дугаар захирамжаар 3 байгууллагын 2,047,422,316.81 төгрөгийн эд хөрөнгийг, 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/299 дугаар захирамжаар "Эрдэнэт ус, ДТС" ОНӨХК-аас 21,926,132.32 төгрөгийн эд хөрөнгийг Жаргалант сумын ЗДТГ-т, 2025 оны 06 дугаар 25-ны өдрийн А/541 дугаар захирамжаар 1,937,833,867,96 төгрөгийн эд хөрөнгийг, 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/732 дугаар захирамжаар 605,278,969.46 төгрөгийн эд хөрөнгийг, 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/855 дугаар захирамжаар 1,363,219,617 төгрөгийн эд хөрөнгийг, 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/936 дугаар 866,172,147.75 төгрөгийн эд хөрөнгийг байгууллага хооронд балансаас балансад шилжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан бөгөөд хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу хийж ажилласан. | 100 хувь <br> 100% |
| 3.1.2 | Арга хэмжээ-2: Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг дахин үнэлэх, үнэлгээг шинэчлэн тогтоох, ашиглалтын хугацааг сунгах, өөрчлөх асуудлаар ирүүлсэн санал, захиалгыг хянах, шийдвэрлүүлэх | Байгууллагын төсвөөр | Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна. | - | Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг дахин үнэлэх, үнэлгээг шинэчлэн тогтоох, ашиглалтын хугацааг сунгах, өөрчлөх асуудлаар ирүүлсэн санал, | Аймгийн Засаг даргын 2025 оны 04 сарын 09-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/278 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс ашиглалтын гэрээгээр эзэмшиж буй байр, талбай, барилга байгууламжийн ашиглалтын байдалд судалгаа, хяналт шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авч, ажлын хэсгийг шийдвэрийг 2025 оны 06 дугаар 24-ний өдөр аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, хөргүүртэй зоорь, Оюуны спортын барилга, Учралтбаяр ӨЭМТ-ийн байрыг Баян-Өндөр сумын ЗДТГ-т шилжүүлсэн, 5 байрыг дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлүүлж, дээрх хөрөнгийн дахин үнэлгээг "Арвижих-эстимейт үнэлгээ" ХХК-иар 2025 оны 06 дугаар сарын 11-ний өдөр хийлгэж, 25/610 дугаар дүгнэлтийг гаргуулсан ба Эрдэнэ | 100 хувь <br> 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | захиалгыг тухай бүр хянан, шийдвэрлүүлэх | багийн конторыг 93,638,840 төгрөгөөр, Эрдэнэ багийн нутагт байрлах Цагдаагийн кабоныг 70,603,930 төгрөгөөр, Чингэл багийн нутагт байрлах Цагдаагийн кабоныг 44,156,420 төгрөгөөр, Баянцагаан багийн өрхийн эмнэлэгийг 107,949,590 төгрөгөөр, Нийцэл өрхийн эмнэлэгийг 127,331,005 төгрөгөөр тус тус үнэлсэн | |
| 3.1.3 | Арга хэмжээ-3: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, актлах санал, захиалгыг судлах, хянаж шийдвэрлүүлэх, хөрөнгийн хөдөлгөөнийг бүртгэх | Байгууллагын төсвөөр | Үйл ажиллагаа хуульд нийцсэн байна. | Хөрөнгө актлах тухай аймгийн Засаг даргын 2 удаагийн шийдвэрийг гаргуулж хэрэгжилтийг хангаж ажилласан. | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, актлах санал, захиалгыг судлах, хянаж шийдвэрлүүлэх, хөрөнгийн хөдөлгөөнийг бүртгэсэн байна. | Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах "А/278 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр орон нутгийн өмчит 16 байр, талбай, барилга байгууламжийн ашиглалттай газар дээр нь үзэж танилцсан. Ажлын хэсэг байр, талбай, барилга байгууламжийн ашиглалтын байдалд хийсэн судалгаа, хяналт шалгалтын дүнг аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд хэргүүртэй зоорийн барилга, Оюуны спортын барилга, Учралтбаяр ӨЭМТ-ийн хуучин байрыг Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлэх, 5 байрыг дуудлага худалдаагаар худалдах шийдвэрийг гаргуулсан. Дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн. Дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн жагсаалтыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлсэн.<br>Орон нутгийн өмчид бүртгэлтэй 11 байгууллагад ашиглагдаж байсан нийт 29 тээврийн хэрэгслийг дуудлагын худалдаагаар худалдах бэлтгэл ажлыг хангаж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх материалыг бэлтгэж хүргүүлсэн.<br>Мөн хөрөнгө актлах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/709 дугаар захирамжаар Орон нутгийн өмчит 41 байгууллагад олон жил ашиглагдан ашиглалтын хугацаа дууссан буюу цаашид сэлбэн ашиглах боломжгүй болсон, ашиглалтын хугацаа дуусаагүй боловч ашиглах боломжгүй болсон 3,079,028,559.08 төгрөгийн балансын үнийн дүнтэй, 2,462,237,867.58 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 616,790,694,50 төгрөгийн үлдэх өртөгтэй, 73,747.51 нэгж хөрөнгийг актлаж данснаас хассан. Ашиглалтын хугацаа дууссан, техникийн хяналтын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүйг тодорхойлж, цаашид ашиглах боломжгүй болсон 822,254,014 төгрөгийн балансын үнийн дүнтэй, 813,404,014 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 8,850,000 төгрөгийн үлдэх өртөгтэй 19 нэгж хөрөнгийг актлаж, шаардлагатай хэсгийг сэлбэг хэрэгслээр | 100 хувь<br>100%. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиглаж, үлдсэн хэсгийг төмрийн хаягдалд тушаасан. 169,100,000 төгрөгийн балансын үнийн дүнтэй, 152,751,040.93 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 16,348,959.07 төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 7 нэгж хөрөнгийг үнэ тогтоон худалдсан. Мөн аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/1003 дугаар захирамжаар орон нутгийн өмчит 16 байгууллагад олон жил ашиглагдаж, ашиглалтын хугацаа дууссан буюу цаашид сэлбэн ашиглах боломжгүй болсон нийт 56,225,137.81 төгрөгийн, 33,492,142.20 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 22,732,995.61 төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг, аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/1003 дугаар захирамжаар акталсан.<br>Одоогийн байдлаар 35 байгууллагаас ирүүлсэн нийт 6,811,731,432.63 төгрөгийн балансын үнийн дүнтэй 6,740,980,235.68 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 69,855,269.45 төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг актлуулах санал ирүүлснийг судлан аймгийн хөрөнгө актлах комиссын гишүүдтэй байгууллага бүр дээр очиж хөрөнгийг шалгаж байна. | |
| 3.1.4 | Арга хэмжээ-4: Орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй барилга байгууламж, эд хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулах зорилгоор холбогдох журам, зааврыг боловсруулах, танилцуулах, түрээсийн төлбөрийн хэмжээг зах зээлийн үнэд нийцүүлэн тогтоох тогтоолын төслийг бэлтгэж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлэх, түрээсийн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, түрээсийн орлогыг төсөвт төвлөрүүлэх | Байгууллагын төсөвөөр | Орон нутгийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн санал хянагдаж, шийдвэрлэгдсэн байна. Түрээсийн орлогын төлөвлөгөө биелсэн байна. | 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 604,2 сая төгрөгийн шууд түрээсийн орлого, дам түрээсийн 60,6 сая төгрөг нийт 664,8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж шууд түрээсийн орлого 88 хувийн, дам түрээсийн орлого 76 хувийн биелэлттэй байна. | Түрээсийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 02/18 дугаар тогтоолоор "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам", "Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам", Орон нутгийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам", "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам"-уудыг, 02/20 дугаар тогтоолоор "Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний загвар", "Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх аргачлал"-ыг "тус тус батлуулсан.<br>Орон нутгийн өмчийн байр талбайн түрээсийн гэрээг 31 байгууллага, 54 иргэнтэй байгуулсан.<br>Түрээсийн орлогын биелэлтийг хангах үүднээс нэхэмжлэхийг хугацаанд нь үүсгүүлэх, орлогын хуулга татаж бүртгэх, иргэн аж ахуй нэгжээс түрээсийн орлогыг тухай бүр төвлөрүүлэн ажиллаж байна.<br>Орон нутгийн өмчийн байрны 2025 оны шууд болон дам түрээсийн орлогын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр батлуулсан. Шууд түрээсийн орлого 668,413,003 төгрөг төвлөрүүлэхээс 603,974,007 төгрөгийг төвлөрүүлж 90,3 хувьтай, дам түрээсийн орлого 66,217,058 төгрөг төвлөрүүлэхээс 60,016,000 төгрөгийг төвлөрүүлж 90.1 хувийн биелэлттэй байна. | 100 хувь<br>90%

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн түрээсийн орон сууц хөтөлбөрөөр хэрэгжсэн 315 айлын орон сууцны эргэн төлөлтөд 2.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлэн ажиллалаа. | |
| 3.1.5 | Арга хэмжээ-5: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайланг цахимаар болон цаасаар хүлээн авч нэгтгэх, санхүүгийн тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон аймгийн Засаг даргын нэгдсэн санхүүгийн тайлантай тулган, хяналт тавих, орон нутгийн өмчийн нэгдсэн дүн мэдээг улсын хэмжээнд нэгтгүүлэх, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах ажлыг зохион байгуулах | Байгууллагын төсвөөр | Хууль тогтоомж хэрэгжсэн байна. | Орон нутгийн өмчит 107 хуулийн этгээдийн 2023 оны эд хөрөнгийн үзлэг тооллогын 630,964,212,709 төгрөгийн дүнг Төрийн өмчийн тооллогын https://umch.sgov.mn/ системд цахимаар нэгтгэн улсын дүнд цаг хугацаанд нь нэгтгүүлсэн. | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч (цахимаар) нэгтгэсэн байна. | Орон нутгийн өмчит 100 хуулийн этгээдийн 786,606,294,424.26 төгрөгийн үндсэн хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан, Сангийн яамны и-балансгай нэгтгэн тулган баталгаажуулж 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт нэгтгүүлсэн.<br>**Хуулийн этгээдийн ангилалаар:**<br>➢ Цэцэрлэг – 31,<br>➢ Сургууль – 17,<br>➢ Төрийн захиргааны байгууллага – 12,<br>➢ Орон нутгийн өмчит хуулийн этгээд – 11,<br>➢ Эрүүл мэндийн байгууллага – 11,<br>➢ Соёлын байгууллага – 10,<br>➢ Нийгэм болон бусад – 8,<br>**Хөрөнгийн ангилал, дүнгээр:**<br>➢ Газар – 34,943,550,600.00<br>➢ Барилга, байгууламж – 337,160,697,2902.00<br>➢ Тээврийн хэрэгсэл – 26,850,758,235.00<br>➢ Машин, тоног төхөөрөмж – 82,079,419,263.26<br>➢ Тавилга, эд хогшил – 16,002,411,466.00<br>➢ Түүх, соёлын дурсгалт зүйлс – 704,024,700.00<br>➢ Дуусаагүй барилга, байгууламж – 148,006,928,539.00<br>➢ Биет бус хөрөнгө – 8,702,419,867.00<br>➢ Бусад үндсэн хөрөнгө – 132,142,748,264.00<br>Орон нутгийн өмчийн 2024 оны дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийн хуралд 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус 5 дугаар хуралдаанаар 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр оруулж хэлэлцүүлэн "Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн 2024 оны дүн батлах тухай" 03/35 дугаар тогтоолоор орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн 2024 оны жилийн эцсийн дүнг нийт 786,606,294,424.26 төгрөгөөр батлуулсан. | 100 хувь<br>100% |
| 3.1.6 | Арга хэмжээ-6: Орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бий болгох, удирдлага, зохицуулалтаар | Байгууллагын төсвөөр | Мэдээллийн санг бүрдүүлж, баяжуулсан байна. | Улсын болон орон нутгийн төсөв, хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар | Бүртгэлийн мэдээллийн санг тухай бүр бүрдүүлж, баяжуулсан байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Баян-Өндөр сум, Жаргалант сумын хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажил болон бараа, болзошгүй аваарын зардлаар хийгдсэн ажлын комисст хөрөнгийн бүртгэл хариуцсан 2 мэргэжилтэн ажиллаж байна. | 100 хувь<br>100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангах, мэдээллийн санг, баяжуулах, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд бүртгэлээр системийн хяналт хийх, дүгнэлт гаргах | | | 99,8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 289 ажил хийгдэж улсын комисс ажиллаж, 18,8 тэрбум төгрөгийн 150 барааны комисст ажиллаж орон нутгийн өмчид бүртгүүлэн, хөдлөл өөрчлөлтийг хийсэн. | | 1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 79,8 тэрбум төгрөгийн 121 ажил, 7,4 тэрбум төгрөгийн 44 гэрээний бараа,<br>2. Баян-Өндөр сумын хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 5,8 тэрбум төгрөгийн 54 ажил, 5,4 тэрбум төгрөгийн 51 гэрээний бараа,<br>3. Жаргалант сумын хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2,2 тэрбум төгрөгийн 23 ажил, 2,4 тэрбум төгрөгийн 48 гэрээний бараа,<br>4. Болзошгүй аваарын зардлаар хийгдсэн 33,1 тэрбум төгрөгийн 204 ажил хүлээн авах комисст тус тус ажилласан.<br>Дээрх ажлуудын хүрээнд шинээр бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагад бүртгэх тухай албан бичиг хүргүүлэн, санхүүгийн программд бүртгэснийг шалган бүртгэлээр системийн хяналт тавин ажиллаж байна. | |
| 3.1.7 | Арга хэмжээ-7: Орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй өмч эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх ажлыг зохион байгуулах, орон нутгийн өмчийн хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт хийх, дүнг нэгтгэн тайлагнах | Байгууллагын төсвөөр | Орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй өмч эзэмшүүлэх гэрээ байгуулсан байна. | - | Орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй өмч эзэмшүүлэх гэрээний тайланг бэлтгэсэн байна. | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн Ээлжит II хуралдааны 02/20 дугаар тогтоолоор Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний загвар, дүгнэх аргачлалыг батлуулсан. Үүний дагуу 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр орон нутгийн өмчит 100 хуулийн этгээдийн дарга, нягтлан бодогч нартай өмч эзэмшүүлэх гэрээг байгуулж, хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна. Ийнхүү гэрээгээр өмч эзэмшүүлснээр эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт сайжирч байна. | 100 хувь<br>100% |
| **ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| 4.1 | ЗОРИЛТ-4: Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, ил тод байдал /ЗДҮАХ-4.2/ | | | | | | |
| 4.1.1 | Арга хэмжээ-1: Иргэний нийгмийн байгууллага болон иргэдийн оролцоо сайжирч, орон нутгийн өмчит байгууллагуудын оновчтой бүтэц бий болж, зохион байгуулалт сайжруулах /ЗДҮАХ-4.2/ | Байгууллагын төсвөөр | Холбогдох заалт бүрийг хэрэгжүүлж, тайланг хугацаанд нь гаргах | - | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ, Хотын захирагчийн алба 2-ын чиг үүрэг давхардаж байна гэж үзсэн тул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 02/21 дүгээр тогтоолоор "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын ангиллыг өөрчлөх, дүрэм, орон тоо, цалингийн нийтлэг жишиг"-ийг батлуулсан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай" 86 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит бус 5 дугаар хуралдаанаар "Мэдээлэл шуурхай удирдлагын төв" УТҮГ-ыг | 100 хувь<br>100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | татан буулгах тухай" асуудлыг хэлэлцүүлэн 03/29 дүгээр тогтоолоор татан буулгасан. | |
| | | | | | | Уг тогтоол гарснаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Аймгийн 2025 оны төсөв батлах тухай" 03/13 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.2.9-т заасан "Мэдээлэл шуурхай удирдлагын төв" гэснийг "Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Теле камерын хяналтын дэд төв" гэж нэршлийг өөрчлүүлсэн. Ажлын чиг үүрэг давхардаж байгаа Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн ашиглалтын өмнөх захиргаа, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж" УТҮГ-ын нэгтгэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/710 дугаар захирамжаар байгуулсан. Ажлын хэсэг "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн" ашиглалтын өмнөх захиргаа, "Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж" УТҮГ-ын бүтэц орон тоог өөрчлөн, давхардлыг арилгах асуудлаар 4 удаа хуралдсан. Ажлын хэсгийн хурлаас "Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж"-ийн газрыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Хот тохижуулах газартай нэгтгэх, "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн" ашиглалтын өмнөх захиргааны зүүн талын хэсгийн тохижилтын ажлыг яаралтай дуусгаж, үйл ажиллагааг жигдрүүлсний дараа татан буулгаж орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компани болгохоор шийдвэрлэсэн. | |
| 4.1.2 | Арга хэмжээ-2: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, орон нутгийн өмчит, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг холбогдох бусад мэдээллийг албан ёсны | Байгууллагын төсвөөр | Холбогдох заалт бүрийг хэрэгжүүлж, тайланг хугацаанд нь гаргах | - | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Орхон аймагт орон нутгийн өмчит 10 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагууд нь "И-МОНГОЛ АКАДЕМИ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР-с хөгжүүлж буй e-mongolia.mn төрийн байгууллагын нэгдсэн удирдлагын системд хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг болон холбогдох бусад мэдээллийг тогтмол байршуулан ажиллаж байна. Төрийн байгууллагын нэгдсэн удирдлагын системээс гадна өөрийн байгууллагын цахим хаягтай "Эрдэнэт ус, ДТС" ОНӨХК нь http://www.erdenet-us.gov.mn, "Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк" ОНӨААТҮГ нь http://www.erdenetpark.mn, "Хот байгуулалт, барилга захиалагчийн газар" УТҮГ нь http://www.erdenetbarilga.mn 3 байгууллага байна. Мөн орон нутгийн өмчит байгууллагууд нь сошиал хаягаараа хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг алдагдлын тайлан, нэгдсэн | 100 хувь<br>100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цахим хуудсанд тогтмол байршуулах -/ЗГХЭГ-ын сайд-2.3.1/- | | | | | төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг болон холбогдох бусад мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна. | |
| 4.1.3 | Арга хэмжээ-3: Орон нутгийн өмчит, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээллийг албан ёсны цахим хуудсанд тогтмол байршуулах /ЗГХЭГ-ын сайд-2.3.3/ | Байгууллагын төсвөөр | Холбогдох заалт бүрийг хэрэгжүүлж, тайланг хугацаанд нь гаргах | - | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Орон нутгийн өмчит "Эрдэнэт ус ДТС" ОНӨХК, "Жаргалант ус ДТС" ОНӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг тус бүр 9 гишүүнтэйгээр байгуулж, ТУЗ-ийн гишүүдийн хувийн ашиг, сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулж "Эрдэнэт ус ДТС" ОНӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01/01 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр Хотын захирагчийн албаны дарга Б.Одгэрэл, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга С.Даваадорж, аймгийн ИТХ-ын Бодлого, төлөвлөлт, хууль, эрх зүйн хэлтсийн дарга Б.Тунгалаг, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баттүвшин, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч С.Энхтүвшин, Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Эрдэнэчимэг, EBS телевиз, TV-9 инфо сүлжээ, Монголын радиогийн Орхон аймаг дахь сурвалжлагч Ж.Баяртогтох, Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэн, Татварын мэргэшсэн нягтлан бодогч В.Хандмаа нарыг, "Жаргалант ус ДТС" ОНӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01/01 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр аймгийн ЗДТГ-ын дарга Б.Ганзориг, аймгийн ИТХ-ын Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтсийн дарга Б.Золоо, аймгийн СТСХ-ийн дарга Л.Ганлсансайнхүвьт, Жаргалант сумын ИТХ-ын Нарийн бичгийн дарга Ц.Ганбаяр, Орон нутгийн өмчийн газрын Өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Баттөр, Хотын захирагчийн албаны Барилгын инженер, ахлах мэргэжилтэн Г.Тулгабаатар, "Эрдэнэт ус ДТС" ОНӨХК-ийн Дулааны инженер Ц.Одбаяр, Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэн Ё.Пэрэнлиймаа, "Холл" ХХК-ийн Санхүүгийн зөвлөх Д.Наранмандах нарыг сонгон шалгаруулах зар мэдээ, сонгон шалгаруулалтын үр дүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилсон шийдвэр болон бусад холбогдох мэдээллүүдийг http://www.erdenet-us.gov.mn, http://www.erdenet.mn, http://www.umch-erdenet.mn сайтуудад байршуулж ажилласан. | 100 хувь 100% |
| 4.1.4 | Арга хэмжээ-4: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21[1]дүгээр зүйлийн 13 дахь хэсэгт заасан | Байгууллагын төсвөөр | Холбогдох заалт бүрийг хэрэгжүүлж, тайланг | - | Орон нутгийн өмчит байгууллагуудын удирдлагатай байгуулах | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захиралтай байгуулсан 2025 оны Хөдөлмөрийн онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд "Үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг | 100 хувь 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
